



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 8/09

Ховд

Б.Эрдэнэцэцэгийг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10, Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолын хавсралтын 14 дүгээр зүйлийн "б" заалт, аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 23 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх Стандарт, хэмжил зүйн хэлтсийн даргаар Бадамжавын Эрдэнэцэцэгийг 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Б.Эрдэнэцэцэгийг Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 2 дахь хавсралтын дагуу ТЗ-9-2 дахь шатлал болох 857852 төгрөг /Найман зуун тавин долоон мянга найман зуун тавин хоёр/-өөр цалинжуулахыг Стандарт, хэмжил зүйн хэлтсийн нягтлан бодогч О.Батзаяад зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Б.Эрдэнэцэцэгт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

02 Зах 5/09 Ч